

ҮНЭТ ЦААСНЫ НОМИНАЛ ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид Төвлөрсөн хадгаламжийн төв гэх), Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ноос Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан этгээдийг гишүүнчлэлээр элсүүлэхэд тавигдах шаардлага, гишүүнээр бүртгэх, бүртгэлээс хасах, мэдээ, мэдээлэл солилцох, түүнд тавигдах хяналт, уг үйл ажиллагаатай холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү харилцаанд Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, болон Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааны журам”, Төлбөрийн үйлчилгээний журам, Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам, болон энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Гишүүнд тавигдах нөхцөл, шаардлага

- 2.1 Төвлөрсөн хадгаламжийн төвийн гишүүнээр бүртгүүлэх Үнэт цаасны компани (цаашид Гишүүн гэх) нь Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.3-т заасан үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг авахад тавигдах шаардлагуудыг хангасан байх;
- 2.2 Программ хангамжид тавигдах шаардлага:
 - 2.2.1 Мэдээллийн технологи, харилцаа холбооны аюулгүй, найдвартай, бүрэн тоноглогдсон орчин бүрдүүлсэн байх;
 - 2.2.2 Цахилгааны хэлбэлзлээс хамгаалах үүднээс эрчим хүчний үүсгүүр, цахилгаан хүчдэл тогтворжуулагчтай байх ба төв компьютер болон харилцаа холбооны төхөөрөмж нь 4-өөс доошгүй цаг ажиллах эрчим хүчээр тогтвортой хангагчтай байх;
 - 2.2.3 Програм хангамжийг ашиглахад зориулсан төв компьютер нь хангалттай хурд, санах ой, хамгаалалт (“програм хангамжид суурилсан” галт хана)-тай байх;
 - 2.2.4 50 болон түүнээс доошгүй тооны харилцагчдад зориулсан сервер, интернетэд нэвтрэх боломж, баримт бичиг хадгалах зай ба цахим шуудантай байх;

- 2.2.5 Ажилтан тус бүр өөрийн хангалттай хурд, хадгалах зай бүхий компьютертэй байх бөгөөд USB оролт, CD/DVD уншигч болон бусад бүх төрлийн гаралтын хэрэгсэл нь түгжигдсэн, зөвхөн мэдээлэл, технологийн администратор болон эрх олгогдсон албан тушаалтан нэвтрэх эрхтэй байх;
 - 2.2.6 Сервер компьютерт зориулсан үндсэн програм хангамж /windows, эсхүл бусад түгээмэл үйлдлийн систем/зохистой хамгаалалтын програм хангамжтай байх ба төв компьютер нь хангалттай хурд, санах ойтой харилцагчийн удирдлагын програм хангамж, галт хана, антивирусын програм ба төв компьютерийн хамгаалалтыг сайжруулах өөр програм хангамжийг багтаасан байна;
 - 2.2.7 Төв компьютерт удирдлагын програмыг суулгасан байх; энэхүү програм нь багц, эсхүл байгууллагын оюуны өмч /proprietary/ байж болно; үйл ажиллагаа явуулахад шаардлагатай функцтэй байх (тухайлбал, үнэт цаасны мэдээллийн сан, харилцагчийн мэдээллийн сан, данс удирдах програм, харилцагчаас өгөх зааварчилгааг боловсруулах, удирдах аппликейшн г.м.)
 - 2.2.8 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэслэлээр мэдээлэл дамжуулахдаа нууцлалын технологи ашиглах;
 - 2.2.9 Гишүүн нь харилцагчдын үнэт цаасыг харилцагч тус бүрээр тухайлсан бүртгэл хөтлөх програм хангамжтай байх бөгөөд цахим холболтоор төвлөрсөн хадгаламжийн төвд илгээх боломжтой байх;
- 2.1 Энэхүү журамд заасан шаардлагыг хангасан үнэт цаасны компани дараах баримт бичгийг бүрдүүлэн Төвлөрсөн хадгаламжийн төвд номинал данс нээх хүсэлт гаргана. Үүнд:
- 2.1.1 Энэхүү журмын Гишүүнчлэлийн гэрээ (Хавсралт 1) болон Гишүүний данс нээх өргөдлийн маягт (Хавсралт 2) данс нээлгэх хүсэлт бүхий албан бичиг;
 - 2.1.2 Хорооноос олгосон мөнгөн хөрөнгийн номинал дансны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
 - 2.1.3 Данс захиран зарцуулах этгээдийг томилсон шийдвэр;
 - 2.1.4 Данс захиран зарцуулах этгээдийн гарын үсгийн баталгаа /нотариатаар гэрчлүүлсэн/
 - 2.1.5 Захиран зарцуулагчийн иргэний үнэмлэхний хуулбар
 - 2.1.6 Үнэт цаасны зах зээл дээр ажил үйлчилгээ явуулах үнэмлэхийн хуулбар
- 2.4 Энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл номинал данс нээх өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор төвлөрсөн хадгаламжийн системд бүртгэнэ;
- 2.5 Төвлөрсөн хадгаламжийн төв нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл данс нээх өргөдлийг хүлээн авахаас татгалзсан тухай хариуг ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ;

ГУРАВ. Үнэт цаасны номинал дансны үйл ажиллагаа

- 3.1 Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх этгээд нь харилцагчийн ашиг сонирхлыг гэрээний үндсэн дээр төлөөлөн оролцох бөгөөд өөрийн болон харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасны дансыг ямагт тусад нь бүртгэнэ;

- 3.2 Төвлөрсөн хадгаламжийн төв нь Гишүүний үнэт цаасны номинал дансыг нээж, харилцагчдын үнэт цаасны төвлөрсөн бүртгэл хөтлөх бөгөөд Гишүүн нь харилцагч бүрээр тухайлсан бүртгэл хөтөлнө;
- 3.3 Гишүүн нь харилцагчийн данс дахь хөрөнгийг зөвхөн харилцагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу харилцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрөл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгаарлах буюу шилжүүлнэ;
- 3.4 Үнэт цаасны номинал дансанд үнэт цаастай холбоотой ногдол ашиг, ногдол хувь, үндсэн ба хүүгийн төлөлт зэрэг мөнгөн хөрөнгө байршиж болох бөгөөд гишүүний хүсэлтээр гишүүний арилжааны банкны дансанд шилжүүлнэ;
- 3.5 Үнэт цаасны номинал дансыг биржийн болон биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжаанд ашиглана;
- 3.6 Үнэт цаастай холбоотой мөнгөн хөрөнгийг Гишүүн нь дотоод системдээ харилцагч тус бүрээр тооцооллыг хийж бүртгэх бөгөөд үнэт цаасны номинал дансанд өөрчлөлт орсон тухай бүр тулгалт хийнэ;
- 3.7 Эрх бүхий байгууллага, хууль хяналтын байгууллагын шийдвэр болон харилцагчийн хүсэлтээр Номинал данс дахь үнэт цаасыг тусгаарлах, чөлөөлөх гүйлгээг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараах байдлаар хийж гүйцэтгэнэ;
 - 3.7.1 Эрх бүхий байгууллага, хууль хяналтын байгууллагын шийдвэр болон харилцагчийн хүсэлт ирсэн даруй Гишүүн тус бүрээс тусгаарлах болон чөлөөлөх үнэт цаасны эцсийн өмчлөгчийг тодорхойлох хүсэлт илгээнэ;
 - 3.7.2 Гишүүн нь харилцагчийн үнэт цаасны үлдэгдэл байгаа эсэхийг шалгаж, ажлын 1 өдрийн дотор буцаан мэдэгдэнэ;
 - 3.7.3 Гишүүнээс тухайн харилцагч үлдэгдэлтэй тухай мэдэгдсэн тохиолдолд Эрх бүхий байгууллага, хууль хяналтын байгууллагын шийдвэр болон харилцагчийн хүсэлтийн дагуу тусгаарлах, чөлөөлөх гүйлгээг хийж, холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ;
- 3.8 Үнэт цаасны номинал данс дах харилцагчдын үнэт цаас нь Гишүүний эзэмшил, өмчлөл биш бөгөөд Гишүүнтэй холбоотой аливаа өр төлбөр, шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь энэхүү дансанд хамааралгүй болно;
- 3.9 Гишүүн нь төвлөрсөн хадгаламжийн төвөөс номинал дансны талаарх хувь хүн, байгууллагын нууцад хамаарагдахгүй тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг гаргуулан авч болно. Үүнд:
 - 3.9.1 Номинал дансны мэдээлэл
 - 3.9.2 Номинал дансны үлдэгдлийн мэдээлэл
 - 3.9.3 Арилжааны мэдээ
 - 3.9.4 Арилжааны бус гүйлгээний мэдээ

ДӨРӨВ. Номинал дансан дахь хөрөнгийг бүртгэх, тулгах, шилжүүлэх

- 4.1 Үнэт цаасны номинал дансанд харилцагчийн нэр дээрх үнэт цаасыг шилжүүлж, бүртгэх, номинал данснаас харилцагчийн тухайлсан дансанд үнэт цаас шилжүүлэх тохиолдолд тухайн үнэт цаас шилжүүлэх өргөдлийн маягт (Хавсралт 3), харилцагчтай байгуулсан гэрээ, үйлчилгээний хураамж төлсөн баримтыг тус тус үндэслэн шилжүүлгийн гүйлгээг хийж гүйцэтгэнэ;

- 4.2 Үнэт цаасны номинал данснаас харилцагчийн тухайлсан дансанд үнэт цаас шилжүүлэх гүйлгээг гүйцэтгэхээс өмнө тухайн үнэт цаас харилцагчийн эзэмшилд байгаа эсэх талаар шалгах зорилгоор Төвлөрсөн хадгаламжийн төв нь гишүүнээс нотлох баримтыг гаргуулан авч, шилжүүлгийн гүйлгээг хийж гүйцэтгэнэ;
- 4.3 Энэхүү журмын 4.1-д заасан шилжүүлгийн гүйлгээнээс бусад өмчлөх эрх шилжүүлгийн гүйлгээг хийхдээ “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам”-ын дагуу хийж гүйцэтгэнэ;
- 4.4 Үнэт цаасны номинал данс дах үнэт цаасны тухайлсан болон төвлөрсөн бүртгэлийн мэдээлэл нь тохирч байх ба Гишүүн нь төвлөрсөн бүртгэлийн үнэн зөв байдлыг баталгаажуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дах бүртгэлтэй 7 хоног бүр тулгалт хийнэ;
- 4.5 Гишүүн нь Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.3.6-д заасан мэдээллийг Төвлөрсөн хадгаламжийн төвд цахимаар болон хэвлэмэлээр ирүүлж байх;
- 4.6 Энэхүү журмын 4.3 дугаарт заасан тулгалтын эцэст харилцагчийн данс дахь үлдэгдэл хөрөнгийн дүнд зөрүү гарсан тохиолдолд талууд гарсан зөрүүг арилган, үлдэгдлийг тааруулах арга хэмжээ авч ажиллана;

ТАВ. Үнэт цаасны номинал дансны хураамж, үйлчилгээний хөлс

- 5.1 Үнэт цаасны номинал данс эзэмшигч нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй 1 жилийн хугацаатай “Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1) байгуулж, жил бүрийн тайлант сарын эхний 10 хоног дотор уг гэрээг сунгах хүсэлтээ Төвлөрсөн хадгаламжийн төвд албан тоотоор мэдэгдэнэ;
- 5.2 Гишүүн нь Төвлөрсөн хадгаламжийн төвд номинал данс нээлгэхдээ гишүүнчлэлийн хураамж болох 1 000 000 /нэг сая/ төгрөгийг нэг удаа төлөх бөгөөд хураамж төлөгдсөнөөр данс нээх эрх нээгдэнэ;
- 5.3 Гишүүн нь дараагийн жилээс жил бүр үйлчилгээний хөлс 1 улирлын 250 000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг Төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд байршуулж төлбөр төлөгдсөнөөр Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээг сунгагдсанд тооцно;
- 5.4 Энэхүү журмын 4.1-д заасан шилжүүлгийн гүйлгээний хураамжийг тооцохдоо тав хүртэлх үнэт цаастай харилцагчийг 2,500 /хоёр мянга таван зуун/ төгрөг, түүнээс дээш үнэт цаастай харилцагч өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг шилжүүлэхэд нэг төрлийн үнэт цаас болгонд 500 /таван зуун/ төгрөг нэмж тооцно; (Хавсралт 3),
- 5.5 Гишүүн нь Энэхүү журмын 5.3-д заасан үйлчилгээний хөлсийг улиралын эхний 10 хоногийн дотор Төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд, 4.1-д заасан үнэт цаасны номинал дансанд харилцагч шилжүүлэх үйлчилгээний хураамжийг тухайн шилжүүлэг хийлгэх дансанд тухай бүр байршуулна;

ЗУРГАА. Хориглох зүйлс

- 6.1 Үнэт цаасны номинал дансаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:
- 6.1.1 Харилцагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүний дансан дах үнэт цаас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах;

- 6.1.2 Үнэт цаасны номинал дансаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан нууцын зэрэглэлтэй болон дотоод мэдээлэл, тайлан, баримт бичгийг найдвартай хадгалан хамгаалж, Үнэт цаас гаргагч болон эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулах;
- 6.1.3 Харилцагчийн нэр, түүний данстай холбоотой өгөгдөл, мэдээллийг бусдад тараах, мэдээлэх;

ДОЛОО. Хариуцлага

- 7.1 Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх этгээд болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд үнэн зөв, бүрэн бүтэн мэдээллийг оруулах үүрэгтэй ба алдаатай мэдээлэл оруулсны улмаас учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна;
- 7.2 Гишүүн нь “Үнэт цаасны номинал дансны үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, болон үзүүлэх үйлчилгээ хууль, дүрэм, журамтай үл нийцсэн үйл ажиллагаа явуулсан буюу дээрх журмын заалтуудыг зөрчсөн нөхцөлд Төвлөрсөн хадгаламжийн төв нь “Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-г цуцлах эрхтэй;
- 7.3 Гишүүн нь журмын шаардлагуудыг биелүүлээгүй нөхцөлд журамд заасан “Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гишүүний гэрээ”-г цуцалж, Төвлөрсөн хадгаламжийн төв нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх хүсэлтийг Хороонд хүргүүлнэ;
- 7.4 Гишүүнээс ирүүлсэн тайлан, тайлбар, хэрэгжүүлсэн арга хэмжээг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд Төвлөрсөн хадгаламжийн төв нь нэмэлт тайлбар, тодруулга ирүүлэхийг шаардаж болно;
- 7.5 Үнэт цаасны тухайлсан бүртгэл хөтлөх нэрийн дор “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын заалтуудыг зөрчсөн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, хуулийн хариуцлага хүлээлгэх талаар дүгнэлт, тайланг тухай бүр Хороонд хүргүүлнэ;

Улаанбаатар хот

2022 он

**Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх
гишүүнчлэлийн гэрээ**

Дугаар...

.... оны ... сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү гэрээгээр талуудын хамтран ажиллах нөхцөл, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” (цаашид Төвлөрсөн хадгаламжийн төв гэх) -ийн төвлөрсөн хадгаламжид үнэт цаасны номинал данс нээх, үнэт цаасны өмчлөх эрх баталгаажуулах, үнэт цаас эзэмшигчийн өмчлөх эрхийн тулгалт хийх, үнэт цаасыг хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар Төвлөрсөн хадгаламжийг төлөөлж овогтой, Үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гишүүнийг төлөөлж байгууллагын овогтой. нар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гишүүний эрх, үүрэг

2.1 Гишүүн нь дараах үүрэгтэй:

- 2.1.1 Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэхдээ “Үнэт цаасны номинал дансны үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангах;
- 2.1.2 Гишүүн нь үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх дотоод бодлого, журмыг боловсруулж, харилцагчтай байгуулах гэрээнд тусган харилцагчид танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулна;
- 2.1.3 Гишүүн нь харилцагчтай номинал дансаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахдаа түүний шаардсанаар өөрийн дотоод дүрэм, журам, санхүүгийн тайлан болон холбогдох хууль тогтоомжид заасан мэдээлэл, баримт бичгийг танилцуулах;
- 2.1.4 “Үнэт цаасны номинал дансны үйл ажиллагааны журам”-ын 5.3 дугаар зүйлд заасан үйлчилгээний хөлсийг улирлын эхний 10 хоног дотор төлсөн байх;
- 2.1.5 Гишүүн нь харилцагчийн ашиг сонирхлыг төлөөлөн оролцох бөгөөд өөрийн болон харилцагчийн үнэт цаасны дансыг ямагт тусад нь бүртгэн хөтлөх;
- 2.1.6 Энэхүү гэрээний дагуу эрх үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах бүхий л мэдээллийг Төвлөрсөн хадгаламжийн төвд мэдээлэх, баримт бичгийг үнэн зөв мэдүүлэх, хүргүүлэх;
- 2.1.7 Төвлөрсөн хадгаламжийн төвийн системээс хүлээн авсан үнэт цаасны өмчлөх

эрхтэй холбоотой тайлан судалгааг өөрийн системийн бүртгэлтэй 7 хоног бүр тулгалт хийж, маягтын дагуу акт үйлдэж байх;

- 2.1.8 Гишүүн нь үнэт цаасны номинал данс хариуцсан ажилтантай байх бөгөөд холбогдох ажилтны нэр, албан тушаалын тодорхойлолт, утас, и-мэйл зэргийг Төвлөрсөн хадгаламжийн төвд албан тоотоор мэдэгдэж байх бөгөөд хэрэв тухайн ажилтан солигдсон эсвэл чөлөөтэй, амралт авсан тохиолдолд орлон гүйцэтгэгчийн мэдээллийг тухайн өдөрт нь албан тоотоор мэдэгдэх;
 - 2.1.9 Өөрийн харилцагчийн төлбөр тооцоо оройтсон эсвэл төлөгдөөгүй нөхцөлд гарсан үр дагавар хариуцлагыг бүрэн хариуцах;
 - 2.1.10 Төвлөрсөн хадгаламжийн систем болон албан маягтаар хүлээн авсан мэдээлэл нь өөрийн системийн харилцагчийн үнэт цаасны өмчлөх эрхтэй зөрсөн нөхцөлд талууд харилцан тулгалт хийж, зөрүү аль талд гарсныг олж тогтоон зөрүүг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллах;
 - 2.1.11 Гишүүн нь өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс татгалзаж гэрээг цуцалсан тохиолдолд энэ талаар Хороонд нэн даруй албан бичгээр мэдэгдэх;
- 2.2 Гишүүн нь дараах эрхтэй:
- 2.2.1 Төвлөрсөн хадгаламжийн төв дээрх үнэт цаасны номинал дансанд өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг системээр ирүүлэхийг Төвлөрсөн хадгаламжийн төвөөс шаардах;
 - 2.2.2 “Үнэт цаасны номинал дансны үйл ажиллагааны журам”-ын 3.9-д заасан мэдээ судалгааг гаргуулан авах;
 - 2.2.3 Гишүүн нь өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс татгалзаж гэрээг цуцлах эрхтэй;

Гурав. Төвлөрсөн хадгаламжийн төвийн эрх, үүрэг

- 3.1 Төвлөрсөн хадгаламжийн төв нь дараах үүрэгтэй:
- 3.1.1 Үнэт цаасны номинал дансны нууцлалыг бүрэн хадгалж, уг данстай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь түргэн шуурхай гишүүнд мэдэгдэх;
 - 3.1.2 Дансны мэдээлэл болон холбогдох хууль дүрэм, журам, заалтад өөрчлөлт орсон тохиолдолд гишүүнд ажлын 3 хоногийн дотор мэдээлэх;
 - 3.1.3 Төвлөрсөн хадгаламжийн дансны үзүүлэлтэд өөрчлөлт орсон тухай бүр системээр мэдэгдэж, 7 хоног бүр тулгалт хийж, маягтын дагуу акт үйлдэж байх,
 - 3.1.4 Төвлөрсөн хадгаламжийн холбогдох ажилтны нэр, албан тушаал, утас, и-мэйл зэргийг гишүүнд албан тоотоор мэдэгдсэн байх бөгөөд хэрэв тухайн ажилтан солигдсон эсвэл чөлөөтэй, амралт авсан тохиолдолд орлон гүйцэтгэгчийн мэдээллийг гишүүний бүртгэлтэй цахим шуудангаар илгээн мэдэгдэх;
 - 3.1.5 2.1.10 дугаарт заасны дагуу Төвлөрсөн хадгаламжийн бүртгэлтэй зөрсөн нөхцөлд талууд харилцан тулгалт хийж үүнээс үүссэн үр дагаврыг Хороонд мэдэгдэх;
 - 3.1.6 Үнэт цаасны номинал дансны аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах;
- 3.2 Төвлөрсөн хадгаламжийн төв нь дараах эрхтэй:

- 3.2.1 ҮЦТХТ нь холбогдох эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл болон баримт бичгээр хангахыг гишүүнээс шаардах;
- 3.2.2 Харилцагчийн өмчлөх эрх бүртгэлтэй холбоотой нэмэлт материалуудыг гишүүнээс гаргуулан авах;
- 3.2.3 Төвлөрсөн хадгаламжийн төв нь үнэт цаасны номинал дансны тухайлсан бүртгэлийг өөрийн хүсэлтийн дагуу гишүүнээс гаргуулан авах эрхтэй;
- 3.2.4 Гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний шимтгэл, хураамжийг төлөхийг шаардах;

Дөрөв. Бусад зүйл

- 4.1 Энэхүү гэрээнд оруулах өөрчлөлт, нэмэлтийг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ. Энэхүү гэрээ болон аливаа нэмэлт гэрээ нь талуудын бүрэн эрх төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 4.2 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 4.3 Талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай аливаа санал тавиагүй бол тухайн гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө уг гэрээг сунгах хүсэлтээ Төвлөрсөн хадгаламжийн төвд албан тоотоор мэдэгдсэнээр уг гэрээг дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

Гэрээ байгуулсан:

Төвлөрсөн хадгаламжийн төвийг төлөөлж:

“ҮЦТХТ” ХХК-ийн ҮЦӨЭБА-ны ахлах ажилтан

.....

Хаяг: Самбуугийн гудамж 16/1, 4 дүгээр хороо Чингэлтэй дүүрэг

Утас: 70120460 Факс: 70114424

Гишүүнийг төлөөлж:

“.....”

.....

Хаяг:

Утас:.....

.....

ҮНЭТ ЦААСНЫ НОМИНАЛ ДАНС НЭЭЛГЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

..... оны сарын-ны өдөр

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ					
1	Номинал данс эзэмшигчийн нэр				
2	Байгуулагдсан огноо		3	Регистрийн дугаар	
ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ					
4	Хаяг				
5	И-майл	6	Утас	7	Факс
ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ					
8	Дансны нэр		9	Дансны дугаар	
ДАНС ЗАХИРАН ЗАРЦУУЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ					
10	Овог		11	Нэр	
12	Регистрийн дугаар		13	Эрхэлсэн ажил	
14	Улсын харъяалал		15	Факс	
16	Утас		17	И-майл	

Захиран зарцуулагчийн гарын үсэг:

.....

Захирал:

.....

ҮЦӨЭБА-ны ажилтан:

.....

ҮЦӨЭБА-ны ахлах ажилтан:

.....

ҮНЭТ ЦААС ШИЛЖҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Номинал дансны харилцагч/

..... оны сарын-ны өдөр

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ				
№			Шилжүүлэгч	Хүлээн авагч
1	Үнэт цаас эзэмшигчийн овог, нэр			
2	Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар			
3	Гэрээний дугаар			
ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ				
№	Үнэт цаасны нэр	Шилжүүлэх үнэт цаас		
		Үнэт цаасны код	Тоо ширхэг	
4				
5				
6				
7				
8				
9				
10				
ДОТООД ХЭРЭГЦЭЭНД				
11	Хүлээн авсан ажилтан:			
12	Гарын үсэг		13	Огноо
14	Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан:			
15	Гарын үсэг		16	Огноо
17	Гүйлгээ хянасан ХӨЭБКА-ны дарга:			
18	Гарын үсэг		20	Огноо

/Иргэн бол иргэний хуулбар, ААН бол гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу/